

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ БҮГД НАЙРАМДАХ АВСТРИ УЛС, МОНГОЛ УЛС ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГЫН ТОХИРОЛЦОО

Нийгмийн хамгааллын тухай Бүгд Найрамдах Австри Улс, Монгол Улс хоорондын хэлэлцээр (цаашид “Хэлэлцээр” гэх)-ийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Улаанбаатар хотноо 2025 оны 5 дугаар сарын 26-ны өдөр гарын үсэг зурсан эрх бүхий этгээдүүд:

- Бүгд Найрамдах Австри Улсын тухайд: Хөдөлмөр, нийгмийн хэрэг, эрүүл мэнд, асрахуй, хэрэглэгчийг хамгаалах Холбооны сайд;
- Монгол Улсын тухайд: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд;

Хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор дараах зүйлсийг хэлэлцэн тохиролцов:

I БҮЛЭГ ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1 дүгээр зүйл Нэр томъёоны тодорхойлолт

Энэхүү Удирдлагын тохиролцоонд хэрэглэсэн нэр томъёо нь Хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд тодорхойлсон нэр томъёотой ижил утгатай байна.

2 дугаар зүйл Харилцагч байгууллагууд

Хэлэлцээрийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу дараах харилцагч байгууллагуудыг томилов:

- Бүгд Найрамдах Австри Улсын тухайд: Нийгмийн даатгалын холбоо;
- Монгол Улсын тухайд: Нийгмийн даатгалын ерөнхий газар.

3 дугаар зүйл Харилцагч байгууллагуудын чиг үүрэг

1. Харилцагч байгууллагууд нь энэхүү Удирдлагын тохиролцоонд заасан чиг үүрэгтэй байна. Харилцагч байгууллагууд нь Хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор харилцан дэмжлэг үзүүлэх ба өөр хоорондоо болон хамаарал бүхий хүмүүс, эсхүл тэдний төлөөллүүдтэй шууд харилцаж болно.
2. Харилцагч байгууллагууд нь Хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай маягтуудыг тохиролцоно.
3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үл харгалзан Хэлэлцэн тохиролцогч 2 талын техникийн шаардлага хангагдсан даруйд Харилцагч байгууллагууд цахим хэлбэрээр мэдээлэл солилцох асуудлыг шуурхай тохиролцоно.

II БҮЛЭГ ХЭРЭГЛЭГДЭХ ХУУЛЬ ТОГТООМЖИД ХАМААРАХ ЗААЛТУУД

4 дүгээр зүйл Хэрэглэгдэх хууль тогтоомжид хамаарах гэрчилгээ

1. Хэлэлцэн тохиролцогч нэг талын хууль тогтоомжийн дагуу Хэлэлцээрийн 7 ба 8 дугаар зүйлд заасан нөхцөл үүсэх тохиолдолд энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан тухайн Хэлэлцэн тохиролцогч талын эрх бүхий байгууллага нь ажил олгогч, эсхүл хувиараа хөдөлмөр эрхлэгчийн хүсэлтээр тухайн ажилтан, хувиараа хөдөлмөр эрхлэгч нь хууль тогтоомжийн дагуу хөдөлмөр эрхэлж байгаа талаар гэрчилгээ олгох ба уг гэрчилгээнд хүчинтэй хугацаа заана. Уг гэрчилгээ нь тухайн ажилтан, эсхүл хувиараа хөдөлмөр эрхлэгчийг Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын албан журмын даатгалаас хууль тогтоомжийн дагуу чөлөөлөгдөхийг батална.

Гэрчилгээний жинхэнэ, эсхүл үнэн зөв эсэхэд үндэслэлтэйгээр эргэлзэж байгаа тохиолдолд энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан Хэлэлцэн тохиролцогч талуудын эрх бүхий байгууллагууд тухайн зөрүүг шийдвэрлэхээр шууд хэлэлцээ хийнэ.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэрчилгээг дараах байгууллагууд олгоно:

Бүгд Найрамдах Австри Улсын хууль тогтоомжийн дагуу өвчний даатгалын асуудал хариуцсан эрх бүхий байгууллага;

Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу нийгмийн даатгалын асуудал хариуцсан байгууллага.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэрчилгээ олгох Хэлэлцэн тохиролцогч талын байгууллага нь уг гэрчилгээний хуулбарыг тухайн ажилтан, түүний ажил олгогч, эсхүл хувиараа хөдөлмөр эрхлэгч болон Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.

III БҮЛЭГ ТЭТГЭМЖИД ХАМААРАХ ЗААЛТУУД

5 дугаар зүйл Тэтгэмжийн хүсэлтийг шийдвэрлэх

1. Эрх бүхий байгууллагууд нь Хэлэлцээрийн 18 дугаар зүйлийн 2 дахь хэсэгтэй холбоотойгоор энэхүү III бүлэгт хамаарч байгаа тэтгэмж авах хүсэлтийг харилцагч байгууллагууд тохиролцсон журмын дагуу шууд мэдээлнэ.
2. Эрх бүхий байгууллагууд тэтгэмжийн хүсэлттэй холбоотой бусад баримтыг харилцан мэдэгдэх бөгөөд шаардлагатай бол эрүүл мэндийн мэдээллийг илгээнэ.
3. Тэтгэмжийн өргөдөл хүлээн авсан Хэлэлцэн тохиролцогч талын эрх бүхий байгууллага нь өргөдөл гаргагчийн болон түүний гэр бүлийн гишүүдтэй холбоотой мэдээллийг нягтлан шалгана. Нягтлан шалгах мэдээллийн төрлүүдийг Хэлэлцэн тохиролцогч хоёр талын харилцагч байгууллагууд зөвшилцөнө.
4. Эрх бүхий байгууллагууд нь тухайн хүсэлтийн шийдвэрийн талаар харилцан мэдээлнэ.

6 дугаар зүйл Тэтгэмжийн төлбөр

1. Эрх бүхий байгууллагууд тэтгэвэр болон бусад тэтгэмжийг хүсэлт гаргагчид, эсхүл тухайн тохиолдолд түүний хууль ёсны төлөөлөгчид шууд олгоно.
2. Хэлэлцээрийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу эрх бүхий байгууллагууд тэтгэмж авагчаас, эсхүл тухайн тохиолдолд түүний хууль ёсны төлөөлөгчөөс тэтгэвэр, тэтгэмжийг үргэлжлүүлэн олгох нөхцөлийн баталгааг шаардах эрхтэй (Хэлэлцэн тохиролцогч талуудын хууль тогтоомжийн дагуу олгосон амьд мэнд болохыг баталсан баримт бичиг).

7 дугаар зүйл

Статистик мэдээлэл

Хэлэлцэн тохиролцогч хоёр талын харилцагч байгууллагууд нь энэхүү Удирдлагын тохиролцооны 4 дүгээр зүйлд заасны дагуу олгосон гэрчилгээний тоо болон Хэлэлцээрийн дагуу тэтгэмж авагчдад олгосон төлбөрийн талаарх статистик тоон мэдээллийг солилцоно. Энэ статистик мэдээлэлд тэтгэмжийн нийт хэмжээ болон тэтгэмж авагчдын тоог агуулна. Энэхүү статистик мэдээллийг жил бүр цахим хэлбэрээр хүргүүлнэ.

IV БҮЛЭГ

ТӨГСГӨЛИЙН ЗААЛТУУД

8 дугаар зүйл

Үргэлжлэх хугацаа

Энэхүү Удирдлагын тохиролцоо нь Хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс хүчин төгөлдөр болох бөгөөд хэлэлцээр ижил хугацаанд хүчинтэй байна.

Удирдлагын тохиролцоог Вена хотноо 2025 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр болон Улаанбаатар хотноо 2025 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр герман, монгол, англи хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд ижил хүчинтэй байна.

Орчуулгын зөрүү гарах тохиолдолд англи эх бичвэрийг баримтална.

Бүгд Найрамдах Австри Улсын
Хөдөлмөр, нийгмийн хэрэг, эрүүл
мэнд, асрахуй, хэрэглэгчийг
хамгаалах Холбооны сайд

Коринна Шуманн

Монгол Улсын
Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн
хамгааллын сайд

Лувсанцэрэнгийн Энх-Амгалан